



2026 он 08 сар 21 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, батлан даалт гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, Говь ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.7.15 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Компани (Зээлдэгчийн хувиар), Таван Богд Холдингс ХХК (Анхны Батлан даагчийн хувиар), Нэмэлт Батлан даагчид болон Азийн Хөгжлийн Банк (Зээлдүүлэгчийн хувиар) нарын хооронд 2026 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байгуулагдах нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээний (цаашид **“Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ”** гэх) нөхцөл болон түүнд тусгагдсан хэлцлүүдийг зөвшөөрч, уг гэрээний дагуу 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан Зээлийн гэрээг (2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтийн гэрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулсан) “Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ”-ний Хавсралт 3-т заасан хэлбэрээр шинэчлэн найруулахыг зөвшөөрсүгэй (цаашид **“Нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан Зээлийн гэрээ”** гэх). Компани нь Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг байгуулах, уг гэрээ ба Нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан Зээлийн гэрээ дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Таван Богд Холдингс ХХК-ийн хамаарал бүхий компаниудын АХБ-тай өмнө байгуулсан дор дурдсан зээлийн гэрээнүүдийн үүргийн гүйцэтгэлд тус тус батлан даалт гаргах, нөхөн төлөх үүрэг (indemnity) хүлээх, холбогдох батлан даалт, нөхөн төлөх үүргийн гэрээг АХБ-тай байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 2.1. Таван Богд Холдингс ХХК, Улаанбаатар Гурил ХХК, Таван Богд Фүүдс ХХК, Таван Богд Фүүдс Пицца ХХК болон АХБ-ны хооронд 2022 оны 12-р сарын 9-ний өдөр байгуулсан 18,000,000 (арван найман сая) ам.долларын зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ;
 - 2.2. Улаанбаатар Гурил ХХК болон АХБ-ны хооронд 2025 оны 04-р сарын 30-ны өдөр байгуулсан 10,000,000 (арван сая) ам.доллар, түүнтэй тэнцэх төгрөг буюу 35,700,000,000 (гучин таван тэрбум долоон зуун сая) төгрөгийн зээлийн гэрээ (нэмэлт, өөрчлөлт бүхий);
3. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.
4. Энэхүү тогтоолын 1 болон 2 дахь хэсгүүдэд заасан Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ, зээл, зээлийн нэмэлт, өөрчлөлт, батлан даалт, нөхөн төлөх үүрэг болон барьцааны гэрээнүүдийн нөхцөл, агуулгыг Компанийн нэрийн өмнөөс хэлэлцэн тохиролцох, барьцаа хөрөнгө нэмэгдүүлэх шаардлагатай тохиолдолд өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх,



2026 он 08 сар 21 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

улмаар Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ, зээлийн, батлан даалт, нөхөн төлөх үүргийн, барьцааны болон бусад холбоотой гэрээнүүдэд Компанийг төлөөлж гарын үсэг зурж, баталгаажуулах, эдгээр гэрээтэй холбоотой мэдэгдэл, баталгаа, гэрчилгээ, маягт, хавсралт болон бусад баримт бичигт гарын үсэг зурах, холбогдох төлбөр тооцоог хийх эрхийг дангаараа эсвэл хамтран хэрэгжүүлэх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б. Амарсайхан), Таван Богд Холдингс ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал (Б.Оргил) нарт тус тус олгосугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУСГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Р.САРАНЦЭЦЭГ

Д.ХҮРЭЛБААТАР